



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДОА-2023/128/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn
Чойбалсан хот 2023 он	Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: “Ари файнэнс аудит” ХХК Утас: 99088151 Цахим хаяг: arifin.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2023.02.24 № 216

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН 2 ДУГААР СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Б.САРАНЦЭЦЭГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Боловсрол шинжлэх ухааны яам 2022 оноос эхлэн төсвийн шинэчлэлийн хүрээнд төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор чанар, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнээр Улсын төсвийн хуваарь болон санхүүжилт БШУЯ, БЕГ-аас шууд хуваарилагдан хянагдаж ирдэг болсон байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, суралцагчийн сурлагын чанарыг хараат бусаар үнэлэх, багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн, бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

**Бусад асуудлын хэсэг**

Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах зорилгоор энэ хичээлийн жилээс Боловсролын нэгдсэн мэдээллийн систем /esis/-ийн бүх үйл ажиллагаа

011020202

мэдээлэл, байршил, үндэсний болон орон нутгийн сургалтад хамрагдсан байдал, сурагчдын үнэлгээ, харьяалал, байршил, асран хамгаалагчийн мэдээлэл, багш нарын цахим журналын шинэчлэл, санхүү, хөрөнгийн мэдээлэл, статистик мэдээлэл зэрэг үйлдлүүд шинэчлэгдэн өөрчлөгдсөнтэй холбогдуулан зохих журам тушаал, шийдвэрийн дагуу цаг хугацаанд нь мэдээллийг оруулснаар мэдээллийн сан бүрдүүлэн ажиллаж байна. Энэ нь БШУЯ болон бусад яамдуудын мэдээллийн эх үүсвэр болон ашиглагдаж байгаагаараа онцлог байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>171,483,206.93</u></b>	<b><u>196,627,225.36</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	33,067,078.93
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	33,067,078.93
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	33,067,078.93
31211	Төрийн сангийн харилцах	-	33,067,078.93
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	171,483,206.93	163,560,146.43
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	500,000.00	48,450.00
35130	Эм боох материал	500,000.00	48,450.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	170,983,206.93	163,511,696.43
35410	Бичиг хэргийн материал	446,700.00	93,500.00
35420	Аж ахуйн материал	2,788,830.00	510,340.00
35450	Барилгын засварын материал	1,071,736.00	
35470	Бусад хангамжийн материал	166,675,940.93	162,907,856.43
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,411,529,714.14</u></b>	<b><u>2,396,327,617.97</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,411,529,714.14	2,396,327,617.97
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,790,269,714.14	1,775,067,617.97
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,951,575,194.44	1,951,575,194.44
39202	Хуримтлагдсан элэгдэл	(217,111,568.60)	(249,194,408.60)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	64,584,364.80	75,379,423.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(57,468,958.44)	(45,741,650.52)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	54,236,749.40	48,545,905.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	(36,078,201.55)	(34,532,146.68)
39214	Бусад үндсэн хөрөнгө	43,399,400.00	43,399,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(12,867,265.91)	(16,043,683.87)
39217	Ном	-	1,679,584.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	621,260,000.00	621,260,000.00
39301	Програм хангамж	1,122,000.00	1,122,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,122,000.00)	(1,122,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	621,260,000.00	621,260,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2,583,012,921.07</u></b>	<b><u>2,592,954,843.33</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,583,012,921.07</u></b>	<b><u>2,592,954,843.33</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,583,012,921.07	2,592,954,843.33
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,034,857,771.64	1,034,857,771.64
51101	Өмч: - төрийн	1,034,857,771.64	1,034,857,771.64
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	712,216,622.63	722,637,764.89
51210	Өмнөх үеийн үр дүн	739,093,833.53	-1,870,317,078.44
51220	Тайлант үеийн үр дүн	(26,877,210.90)	2,592,954,843.33
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	835,938,526.80	835,459,306.80
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>2,583,012,921.07</u></b>	<b><u>2,592,954,843.33</u></b>

Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	702,637,712.12	3,461,715,834.07
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	650,403,422.12	2,602,912,466.07
120	Нийтлэг татварын бус орлого	30,769,522.12	2,602,912,466.07
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	30,769,522.12	1,897,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,897,800.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө	30,769,522.12	2,413,209,298.14
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Бараа материал		187,805,367.93
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	619,633,900.00	
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	619,633,900.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	52,234,290.00	858,803,368.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		778,273,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		778,273,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,489,690.00	4,498,368.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,489,690.00	4,498,368.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,744,600.00	76,031,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,744,600.00	76,031,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	726,084,235.02	868,760,990.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	726,084,235.02	868,760,990.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	695,158,650.76	814,885,791.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	510,298,699.00	582,112,068.66
210101	Үндсэн цалин	436,033,511.00	440,386,598.86
210102	Нэмэгдэл	29,744,446.00	113,244,881.80
210104	Урамшуулал	44,520,742.00	28,480,588.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,921,330.00	71,791,877.58
210201	Тэтгэврийн даатгал	47,624,278.00	50,330,794.75
210202	Тэтгэмжийн даатгал	5,121,244.00	5,899,794.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,096,835.00	4,665,396.76
210204	Ажилгүйдлийн даатгал	1,101,206.00	987,407.89
210205	Эрүүл мэндийн даатгал	9,977,767.00	9,908,483.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,617,541.74	31,522,316.52
210301	Гэрэл, цахилгаан	7,110,577.00	9,508,554.06
210302	Түлш, халаалт	14,071,633.74	15,298,551.46
210303	Цэвэр, бохир ус	4,435,331.00	6,715,211.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,818,160.00	31,152,689.50
210401	Бичиг хэрэг	1,416,254.00	5,097,561.00
210402	Тээвэр, шатахуун	600,000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,034,100.00	
210404	Ном, хэвлэл	560,000.00	7,495,818.18
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	305,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,902,806.00	18,559,310.32
2105	Нормативт зардал	17,973,625.00	29,970,491.03

**Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	684,100.00	824,550.00
210502	Хоол, хүнс	15,871,425.00	29,145,941.03
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,418,100.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,979,744.00	3,055,236.00
210604	Урсгал засвар	17,979,744.00	3,055,236.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,027,760.00	8,079,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,027,760.00	1,897,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	6,181,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,521,791.02	57,201,712.17
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	9,866,623.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,358,670.02	5,684,939.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,163,121.00	41,650,150.17
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,925,584.26	53,875,199.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,559,320.00	47,075,868.80
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,826,000.00	42,577,500.80
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	18,733,320.00	4,498,368.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,239,206.00	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,239,206.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,127,058.26	6,799,330.48
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,127,058.26	6,799,330.48
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(23,446,522.90)</u>	<u>2,592,954,843.33</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,430,688.00	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	3,430,688.00	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(3,430,688.00)	
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(26,877,210.90)</u>	<u>2,592,954,843.33</u>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>671,868,190.00</u></b>	<b><u>860,701,168.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>619,633,900.00</b>	1,897,800.00
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	1,897,800.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	-	1,897,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,897,800.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>52,234,290.00</b>	858,803,368.00
<b>1310</b>	Улсын төвлөрсөн төсвөөс		778,273,600.00
<b>131001</b>	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		778,273,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	23,489,690.00	4,498,368.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,489,690.00	4,498,368.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	28,744,600.00	76,031,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,744,600.00	76,031,400.00

Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>671,868,190.00</b>	<b>802,865,619.07</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>671,868,190.00</b>	<b>802,865,619.07</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>640,942,605.74</b>	<b>748,990,420.59</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	510,298,729.00	582,121,651.66
210101	Үндсэн цалин	436,033,541.00	439,877,380.86
210102	Нэмэгдэл	29,744,446.00	113,244,881.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	518,801.00
210104	Урамшуулал	44,520,742.00	28,480,588.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	67,921,300.00	71,782,294.58
210201	Тэтгэврийн даатгал	47,624,278.00	50,321,211.75
210202	Тэтгэмжийн даатгал	5,121,244.00	5,899,794.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,096,835.00	4,665,396.76
210204	Ажилгүйдлийн даатгал	1,101,176.00	987,407.89
210205	Эрүүл мэндийн даатгал	9,977,767.00	9,908,483.60
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	25,617,541.74	31,522,316.52
210301	Гэрэл, цахилгаан	7,110,577.00	9,508,554.06
210302	Түлш, халаалт	14,071,633.74	15,298,551.46
210303	Цэвэр, бохир ус	4,435,331.00	6,715,211.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	17,198,525.00	29,145,941.83
210502	Хоол, хүнс	15,871,425.00	29,145,941.83
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,000,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,027,760.00	8,079,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,027,760.00	1,897,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	6,181,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6,602,400.00	24,338,816.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	15,066,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,602,400.00	9,272,116.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>30,925,584.26</b>	<b>53,875,198.48</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	28,559,320.00	47,075,868.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,826,000.00	42,577,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	18,733,320.00	4,498,368.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	1,127,058.26	6,799,330.48
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,127,058.26	6,799,330.48
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	≡	<b>57,835,548.93</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	-	<b>24,768,470.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>24,768,470.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	24,768,470.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	24,768,470.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	≡	<b>(24,768,470.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	33,067,078.93
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	33,067,078.93

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,034,857,771.64	835,938,526.80	712,216,622.63	2,583,012,921.07
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,034,857,771.64	835,938,526.80	712,216,622.63	2,583,012,921.07
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(2,582,533,701.07)	(2,582,533,701.07)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,034,857,771.64	835,938,526.80	(1,870,317,078.44)	479,220.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(479,220.00)	-	(479,220.00)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	2,592,954,843.33	2,592,954,843.33
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,034,857,771.64	835,459,306.80	722,637,764.89	2,592,954,843.33

## 2.5 Аудит хийсэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Данс	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	856,802,800.00	823,135,721.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	856,802,800.00	823,135,721.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	806,518,769.52	773,758,890.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	606,793,663.00	582,121,651.66
210101	Үндсэн цалин	454,824,300.00	439,877,380.86
210102	Нэмэгдэл	140,510,038.00	113,244,881.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	518,801.00
210104	Урамшуулал	11,459,325.00	28,480,588.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,593,890.00	71,782,294.58
210201	Тэтгэврийн даатгал	51,418,050.00	50,321,211.75
210202	Тэтгэмжийн даатгал	6,050,706.00	5,899,794.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,837,005.00	4,665,396.76
210204	Ажилгүйдлийн даатгал	1,208,030.00	987,407.89
210205	Эрүүл мэндийн даатгал	12,080,099.00	9,908,483.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,522,316.52	31,522,316.52
210301	Гэрэл, цахилгаан	9,508,554.06	9,508,554.06

**Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210302	Түлш, халаалт	15,298,551.46	15,298,551.46
210303	Цэвэр, бохир ус	6,715,211.00	6,715,211.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>30,435,400.00</b>	<b>29,145,941.83</b>
210502	Хоол, хүнс	30,435,400.00	29,145,941.83
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,000,000.00</b>	<b>2,000,000.00</b>
210604	Урсгал засвар	8,799,330.48	2,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,079,400.00</b>	<b>8,079,400.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,897,800.00	1,897,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,181,600.00	6,181,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>52,094,100.00</b>	<b>49,107,286.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,821,700.00	39,835,170.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,272,400.00	9,272,116.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>50,284,030.48</b>	<b>49,376,830.48</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>43,484,700.00</b>	<b>42,577,500.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	43,484,700.00	42,577,500.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>856,802,800.00</b>	<b>856,202,800.00</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>778,273,600.00</b>	<b>778,273,600.00</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	778,273,600.00	778,273,600.00
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>2,497,800.00</b>	<b>1,897,800.00</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,897,800.00	1,897,800.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	33,067,078.93
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>76,031,400.00</b>	<b>76,031,400.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	76,031,400.00	76,031,400.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,498,368.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,498,368.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4498368.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,498,368.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,498,368.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4498368.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,498,368.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,498,368.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

#### 3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Дансны үлдэгдэлтэй холбоотой асуудал

###### Илрүүлэлт:

Татварын тодорхойлолтоор 1,150.5 мянган төгрөгийн илүү төлөлттэй байгаа боловч санхүүгийн байдлын тайлан дахь татварын авлага дансанд үлдэгдэлгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.7-д заасан "Аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хянах тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах" заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "үнэлгээ", "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

Ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах, өглөг авлагыг бүрэн баталгаажуулж ажиллах

##### 2. Нийт орлоготой холбоотой асуудал

Түрээсийн номноос орсон орлогыг аккурэл сууриар бүртгээгүйгээс орлогыг дутуу илэрхийлсэн байх, нотлох баримтгүй, тайлан тооцоо гаргаж ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Түрээсийн номноос орсон орлогыг аккурэл сууриар бүртгэн бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

##### 3. Бараа материалтай холбоотой асуудал

Бараа материалын дансанд хандиваар бүртгэсэн 1,245.8 мянган төгрөг нотлох баримт санхүүгийн баримтанд байхгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байх, иж бүрэн, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэж хэвших.

##### 4. Тооллого, тооцоотой холбоотой асуудал

Байгууллагын даргын тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого зохион байгуулах комиссыг томилж хөрөнгийн тооллогыг гүйцэтгүүлсэн боловч тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай

хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2. "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1. "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" заалт; 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эд хөрөнгийн тооллого хийгдсэний дараа хөрөнгийн тооцоог бодож, тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулсан байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### 4.1. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын даргын тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого зохион байгуулах комиссыг томилж хөрөнгийн тооллогыг гүйцэтгүүлсэн боловч тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.	1	-				-	1	
Бараа материалын дансанд хандиваар бүртгэсэн 1,245.8 мянган төгрөг нотлох баримт санхүүгийн баримтанд байхгүй байна.	1	1,245.8					1	1,245.8
Татварын тодорхойлолтоор 1,150.5 мянган төгрөгийн илүү төлөлттэй байгаа боловч санхүүгийн байдлын тайлан дахь татварын авлага дансанд үлдэгдэлгүй байна.	1	1,150.5					1	1,150.5
Түрээсийн номноос орсон орлогыг аккурэл сууриар бүртгээгүйгээс орлогыг дутуу илэрхийлсэн байх, нотлох баримтгүй, тайлан тооцоо гаргаж ажиллаагүй зэрэг зөрчил гаргаж бүртгэлээр тавих хяналтыг сулруулсан байна.	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>2,396.3</b>					<b>4</b>	<b>2,396.3</b>